ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 21 (546)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай*
- *Сургуулийн өмнөх боловсролын тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2008 оны зургадугаар сарын 6 №21 (546)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

314.	Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	502
315.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	504
316.	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	505
317.	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	506
318.	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	507
319.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	507
320.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	508
321.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	520
322.	Сургуулийн өмнөх боловсролын тухай	521
323.	Бага, дунд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	526
324.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	527
325.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	527
326.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	527
327.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	527
328.	Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	528
329.	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай	528
330.	"Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах чухал	528

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

331.	Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай	Дугаар 30	529
332.	Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай	Дугаар 41	530
333.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 43	534
334.	Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалт батлах тухай	Дугаар 47	535
335.	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 48	537
336.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай	Дугаар 49	538
337.	Орон даяар гашуудал зарлах тухай	Дугаар 50	538

338.	Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 51	539
	Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
339.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 79	539
340.	Ажилд томилох тухай	Дугаар 80	539
341.	Шинжлэх ухаан,технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын орон тоо батлах тухай	Дугаар 81	540
342.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 87	540
343.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 99	540

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 2[1],4, 11, 12, 13, 15,16, 28 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 2[1] дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"12/"хуримтлалын сан" гэж нийгмийн даатгалын сангийн хөренгө болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нөөцөлсөн мөнгөн хөренгийг."

2/ 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажилласан байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5-д зааснаас бусад төрлийн даатгалд заавал даатгуулна."

3/ 11 дүгээр зүйлийн 3,4,5 дахь хэсэг:

"3.Хуримтлалын сангийн хөренгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно.

4.Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөренгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална.

5.Хуримтлалын сангаас арилжааны банкинд байршуулах хөренгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно."

4 /12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Төсвийн байгуллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг тухайн жилийн улсын төсвийн төслийн хамт Засгийн газарт мэдүүлнэ.

Засгийн газар нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг улсын төсвийн төслийн хамт Улсын Их Хуралд 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор өргөн мэдүүлнэ."

5/13 дугаар зүйлийн 3,4,5 дахь хэсэг:

"3.Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн байгуллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.1-д заасан тайланд тусгаж, Засгийн газар болон Улсын Их Хуралд тайлагнана.

4.Нийгмийн даатгалын сангийн зарцуулаптын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

5.Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тайлан, мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан аудитын дүгнэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцүүж, улсын төсвийн гүйцэтгэлийг баталснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлнэ."

6/ 15 дугаар зүйлийн 7,8 дахь хэсэг:

"7.Засгийн газар жил бүр даатгуулагчийн шимтгэл төлөх орлогын дээд хэмжээг Үндэсний статистикийн хороноос гаргасан дундаж цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэр тус бүрээр ялгавартайгаар тогтооно.

8.Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажилаж байгаа Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно."

7/ 16 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг:

"7.Хуанлийн жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтныг жилийн туршид нийгмийн даатгалд даатгуулсанд тооцно.

8.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр төлнө."

8/ 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаат эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад "хүү" гэсний дараа ",үнэт цаасны арилжааначас олсон орлого;", 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад "Нийгмийн даатгалын" гэсний дараа "байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн", 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад "алданги ногдуулна." гэсний дараа "Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.", мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад "0.3 хувийн алданги ногдуулна." гэсний дараа "Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэж, 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад "Үндэсний зөвлөл ажлын албатай байна." гэсэн догол мөр тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4, 6, 15, 27, 31, 32 дугаар зүйлийн даралах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан заавал даатгуулна:

1/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага; иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд зааснаар иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

2/Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа тесел, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

3/хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч;

4/хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн."

2/4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тодорхой хөдөлмөр эрхлэгчий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуульд заасан болзол, журмын дагуу энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 4 дэх заалтад дурдсан даатгалд сайн дураар даатгуулж болно. Сайн дураар даатгуулагч нь дээр дурдсан нийгмийн даатгалын төрөл тус бүрд хамрагдана."

3/ 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч бүрэн хариуцаж төлнө."

4/ 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнийх тэтгэврийн даатгалд 10 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна."

5/ 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалт:

"6/нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, нийгмийн даатгалын сангийн төсвийн теслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих;"

6/ 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэх нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар тогтооно."

7/ 32 дугаар зүйл:

"32 дугаар зүйл. Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого

1.Дараахь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна:

1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор;

2/Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс;

3/энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлого;

4/аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого."

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "нэг төрлийн сангийн хөрөнгийг өөр төрлийн санд шилжүүлэн зарцуулах" гэснийг "нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах", 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "нийгмийн даатгалын байгууллагын төвөрсөн хөрөнгө даансанд" гэснийг "нийгмийн даатгалын сангийн даансанд" гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн "тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын байгууллагад төлнө" гэснийг "нийгмийн даатгалын сангийн даансанд шилжүүлнэ", 12 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн дугаарыг "3", "4", 15 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийн дугаарыг "6","7" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "Нийгмийн даатгалын төв байгууллагын дарга нь Үндэсний эдийн засаг, сангийн яам гишүүн байна." гэсэн өгүүлбэрийг хассугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр — **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/ 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7дахь заалт:

"7/хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсний болон амаржсаны амралттай байсан хугацаа;"

2/ 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-оос доошгүй жил ажилласан, эхэлж нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас

доошгуй жил дурьдсан мэргэжлээр ажиллаж, тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсен иргэн, мөн 25-аас доошгуй жил тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй."

3/ 21[1] дүгээр зүйл:

"21[1] дүгээр зүйл. Оршуулгын тэтгэмжийн хэмжээ

Оршуулгын тэтгэмжийн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална."

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4[1] дүгээр зүйлийн "хөдөлмөрийн" гэсний дараа "болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Тэтгэмж бодох хувь хэмжээ 5 хүртэл жилд "45 хувь" гэснийг "50 хувь", 19[2] дугаар зүйлийн 1 дахь хэсгийн "70" гэснийг "100", 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалтын дугаарыг "8/" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ны өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИЙГ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 7 дахь заалт:

"7/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал."

2/17[1] дугаар зүйл:

"17[1] дугаар зүйл. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

1/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт;

2/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон суртачилгаа.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний зардлын хэмжээ, санхүүжүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална."

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "зардлыг" гэсний дараа "галт тэрэг, автомашины тухайн үед мөрдөж буй тарифыг үндэслэн" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "мэргэжлийн ажилтныг" гэснийг "мэргэжлийн ажилтан, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийг", 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "жагсаалтыг эрүүл мэндийн" гэснийг " жагсаалт, хувь хэмжээг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын", 11 дүгээр зүйлийн "хөлснөөс" гэснийг "хөлс, түүнтэй адилтгах орлогоос", 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хөдөлмөрийн хөлсний" гэснийг "хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын", 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "мэргэжлийн эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанарын хяналтын комисс, уг комисс байхгүй" гэснийг "эмнэлгийн байгууллагын эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр, зөвлөгөөний шийдвэр гаргах боломжгүй", 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "5" гэснийг "3" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 08-ний өдөр

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/17[1] дугаар зүйл:

"17[1] дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх

1.Цэргийн албан хаагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эх хүүхдээ 196 хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

3.Цэргийн албан хаагч эмэгтэй хууль тогтоомжид заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн бол түүнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрелт хамаарна."

2/17[2] дугаар зүйл:

"17[2] дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, хугацаа

1.Цэргийн албан хаагч эхэд сүүлийн 12 сард авсан цалин хөлсний дундаж 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд тэтгэмж олгоно.

2.Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно."

3/3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/жирэмсний болон амаржсаны тэтгэмж."

2 дугаар зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7 дугаар зүйл. Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох

1.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсөнд дараахь цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг оруулан тооцно:

1/Төрийн албаны тухай хуулийн 28.2.3-т заасан цалин хөлс, болон бусад хууль тогтоомжийн дагуу олгогдох нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал;

2/цэргийн байгууллагаас цэргийн албан хаагчид олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого."

2.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хуваах тодорхойлно.

3.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нэг удаагийн тэтгэмж олгоход баримтлах сарын дундаж цалин хөлсийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлно.

4.Цэргийн албан хаагчийн алба хаж байсан анги, салбарын хоёрдогч албан тушаалтан нь тухайн цэргийн албан хаагчийн цалин хөлсийг үнэн зөв тодорхойлох үүрэгтэй."

3 дугаар зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтын "генерал" гэсний дараа "комиссар", Тавдугаар бүлгийн гарчигт "Хөдөлмөрийн чадвар түр алдсаны" гэсний дараа ", жирэмсний болон амаржсаны" 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хөдөлмөрийн чадвар түр алдсаны" гэсний дараа ", жирэмсний болон амаржсаны" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.7 дахь хэсэг нэмсүгэй:

"6.7. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 6.1, 6.2-т заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 8, 9 дэх заалт, 6.2 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн 8, 9 дэх заалт:

8	Авто-бензин	90 хүртэл октантай	1 тонн	0-11.00	-
		90 ба түүнээс дээш октантай	1 тонн	0-12.00	-
9	Дизелийн түлш		1 тонн	0-15.00	-

2/ 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"6.2. Энэ хуулийн 4.1.3-т заасан автобензин, дизелийн түлшийг импортлон оруулж байгаа хилийн боомтоос хамаарууллан дараахь хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /ам. доллларт шилжүүлснээр/		
		Автобензин /шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ/		Дизелийн түлш
		90 хүртэл	90 ба түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуун сухайт	0-11.00	0-12.00	0-15.00
2	Ханх, Ульхан майхан	0-17.00	0-21.00	0-19.00
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	0-38.00	0-43.00	0-48.00

"

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 11.3, 11.4 дэх хэсэг нэмсүгэй:

"11.3.Нэмэгдсэн өртгийн албан татварыг импортлосон болон үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшний албан татвар тооцох үнэлгээний 0-10 хувиар ногдуулна.

11.4.Импортлосон болон үйлдвэрлэсэн автобензин, дизелийн түлшний нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 11.3-т заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндэсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын үдирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж

2.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж нь Үндэсэн хууль[1], Хөдөлмөрийн тухай хууль,[2] энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, эохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг;

3.1.2."хөдөлмөрийн аюулгүй байдал" гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байхыг;

3.1.3."хөдөлмөрийн эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад химий, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа;

3.1.4."хөдөлмөрийн нөхцөл" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан бүюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;

3.1.5."үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл" гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох урьшг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;

3.1.6."үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл" гэж ажлын ээлжийн хугацаанд хүрц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг;

3.1.7."ажлын байран дахь эрсдэл" гэж иргэнийг үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг;

3.1.8."эрсдэлийн үнэлгээ" гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг;

3.1.9. "ажлын байр" гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;

3.1.10."хүрц хордлого" гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хүрц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;

3.1.11."түсгай хувцас" гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг;

3.1.12."нэг бүрийн хамгаалах хэрэгсэл" гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай

[1] Монгол Улсын Үндэсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[2] Хөдөлмөрийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

хучин зүйлийн нөлөөлөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

3.1.13."хамтын хамгаалах хэрэгсэл" гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хучин зүйлийн нөлөөлөөс хоёр ба түүнээс дээш тооны ажилтныг нэгэн зэрэг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

3.1.14."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент" гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг;

3.1.15."ахуйн байр" гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагаат хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсэн хувцас солих, тур амрах, хооллох, бие засах, усанд орох, дупаацах зэрэг зориулалтын өрөө тасалгааг;

3.1.16."үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах" гэж гүйцэтгэж буй ажлын аюултай, хортой, хүнд, ачаалалтай байдал нь хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн хэм хэмжээнд нийцэж байгаад үнэлгээ өгөхийг;

3.1.17."хөдөлмөрийн аюулгүй нөхцөл" гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хучин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрэгүй байхыг;

3.1.18."үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал" гэж зураг тесөл, техникийн баримт бичиг заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;

3.1.19."хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт" гэж хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль нь ажил, хөдөлмөр эрхэлж буй дараахь этгээдэд үйлчилнэ:

4.1.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан ажил олгогч, ажилтан;

4.1.2. хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;

4.1.3.иргэд хоорондын гэрээгээр ажиллагчид;

4.1.4. аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч, цэргийн сургуулийн сонсогч;

4.1.5. хугацаат ба гэрээт цэргийн жинхэнэ албан хаагч, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн;

4.1.6. хоршоо, нөхөрлөлийн гишүүд;

4.1.7. ял эдэлж байгаа хоригдол;

4.1.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгуллагад ажилладаг Монгол Улсын иргэн, гадаадын болон харьяалалгүй иргэн.

4.1.9. хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр болон бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхэлж буй Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн.

5 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, зарчим

5.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлогын үндэс нь хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг бүх талаар хамгаалахад чиглэгдэнэ.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хэм хэмжээний шаардлага нэгдмэл байх;

5.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх байнгын хяналтын тогтолцоог хангах;

5.2.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдээллийн ил тод, үнэн бодит байдлыг хангах;

5.2.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлийг бүрдүүлсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт

6 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт

6.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хууль тогтоомжоор тогтоох бөгөөд хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн, нэгдмэл байна.

6.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн стандартын асуудал эрхэлсэн байгууллага холбогдох хуулийн дагуу батална.

7 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн барилга байгууламжид тавих шаардлага

7.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, машин техник, тоног төхөөрөмж үгсрах, суурилуулах, туршилт, засвар хийх үйлчилгээ нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагааг явуулахдаа холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.

8 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хамтран эзэмших, ашиглахад тавих шаардлага

8.1.Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хоёр бүюу түүнээс дээш ажил олгогч хамтран эзэмших, эсхүл ашиглаж байгаа бол эзэмшигч, ашиглагч дараахь шаардлагыг хангах үүрэгтэй:

8.1.1.эзэмшигч, ашиглагч нь үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах талаар журам тогтоон мөрдөж ажиллах;

8.1.2.үйлдвэрлэлийн явцад химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисыг хэрэглэж буй эзэмшигч, ашиглагч нь энэ тухай харалцан бие биедээ мэдээлж, аюулгүй байдлыг хангах нэгдсэн арга хэмжээ авах;

8.1.3.энэ хуулийн 8.1.2-т заасны дагуу мэдээлэгүйн улмаас учирсан хохирлыг бууруутай тал нь хариуцах.

8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хамтран эзэмшихийг хориглоно.

9 дүгээр зүйл. Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага

9.1.Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн талаар ажил олгогч нь дараахь шаардлагыг хангасан байна:

9.1.1. машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх;

9.1.2. машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх;

9.1.3 машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх;

9.1.4 машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байх.

9.2.Машин механизм, тоног төхөөрөмжийг бүсдад шилжүүлэхдээ ашиглалтын паспорт, гэрчилгээний хамт шилжүүлнэ.

9.3.Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна.

9.4.Цахилгааны тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу үгсрагдсан, газардуулга, газардуулгын даацын баталгаат мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

9.5.Энэ хуулийн 9.1-9.4-т заасан шаардлагыг хангаагүй машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

10 дугаар зүйл. Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавих шаардлага

10.1.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.

10.2.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд мэргэжлийн байгууллагаар техникийн магадлагаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байна.

10.3.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан болон эрх бүхий байгууллагын батлагаа хугацаанд туршилт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэсэн байна.

10.4.Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3-т заасан шаардлага хангагдсан байх нөхцөлийг ажил олгогч хангасан байна.

11 дүгээр зүйл. Даралтат сав, шугам хоолойд тавигдах шаардлага

11.1. Даралтат сав, шугам хоолой нь даралтыг шаардлагыг хангасан байна.

11.1.1. даралтат сав, шугам хоолойд зохих журмын дагуу туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгэж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглах зөвшөөрөл авсан байх;

11.1.2. даралтат сав, шугам хоолойг аюулгүй ашиглах, удаан хугацаагаар зогсоох болон хадгалах үеийн ашиглалтын журамтай байх;

11.1.3. даралтат сав, шугам хоолойг зориулалтын ялгаатай таних тэмдэг, оспоос урьдчилан сэргийлэх дохиоллын болон хамгаалалтын хэрэгслээр тоноглосон байх.

12 дугаар зүйл. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага

12.1.Ажил олгогч нь химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис, түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

12.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн явцад хэрэглэж байгаа химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын талаар тэмдэглэл хөтөлж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн хяналтын болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлнэ.

12.3.Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцан ажиллагч нь тухайн бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг, дадлагатай байна.

12.4.Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэх, харьцах аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавигдах бүсад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна.

12.5.Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын хэрэглээтэй холбоотой осол, хурц хордлого гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судлан буртгэнэ.

13 дугаар зүйл. Галын аюулгүй байдалд тавих шаардлага

13.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

13.2.Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

13.3.Галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг Галын аюулгүй байдлын тухай[2], Захиргааны хариуцлагын тухай[4] хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг

14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийгдэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.

14.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд гүйцэтгэж буй тухайн ажил, хөдөлмөрт шаардлагатай бол эмнэлгийн үзлэгт орсон байна.

14.4.Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

[2] Галын аюулгүй байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 27 дугаарт нийтлэгдсэн.
[4] Захиргааны хариуцлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

15 дугаар зүйл. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.

15.2. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.

15.3. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

15.4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулсан байна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд энэ заалт хамаарахгүй.

16 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага

16.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна.

16.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна.

17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тух сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан тух сургалт нь дараахь төрлөөр зохион байгуулагдаж болно:

17.2.1. шинээр ажилд орж байгаа иргэний сургалт;

17.2.2. өөр ажлын байранд шилжиж байгаа иргэн, ажилтны сургалт;

17.2.3. үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа иргэн, ажилтны сургалт.

17.3.Энэ хуулийн 17.2.3-т заасан ажлын байранд зохих сургалтад хамрагдаж, дадлага хийж, шалгалтанд тэнцсэн иргэнийг ажиллуулна.

17.4.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтныг хамруулан, шалгалт авч байна.

17.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн түр сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх хөтөлбөрийг Боловсролын тухай[5], Дээд боловсролын тухай[6] хуулийн дагуу зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх, үүрэг

18 дугаар зүйл.Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулахтай холбогдсон эрх, үүрэг

18.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараахь нийтлэг эрхтэй байна:

18.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;

18.1.2.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;

18.1.3.ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;

18.1.4.ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;

18.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хэлэлцэхэд өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох.

[5]Боловсролын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.
[6]Дээд боловсролын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

18.2.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараахь нийтлэг үүрэгтэй байна:

18.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;

18.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;

18.2.3.хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;

18.2.4. эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;

18.2.5. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;

18.2.6. ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмшиж, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;

18.2.7. өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;

18.2.8. ажил олгочийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах байгуллагын тогтолцоо, бүрэн эрх, санхүүжилт

19 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах байгуллагын тогтолцоо

19.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах төрийн байгуллагын тогтолцоо нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага, түүний харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгуллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгуллага, хяналтын байгуллага, аж ахуйн нэгж, байгуллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, ажилтнаас бүрдэнэ.

20 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

20.1.Улсын Их Хурал нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи үндэсний бодлогыг тодорхойлох;

20.1.2. онцгой байдлын үед хүн амын амь нас, эрүүл мэндийг хамгаалах асуудлаар Засгийн газар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага болон холбогдох бусад байгуллагын бүрэн эрхийг тодорхойлох;

20.1.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

20.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

21 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

21.1.Засгийн газар нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

21.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

21.1.3.өөрийн бүрэн эрхийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар гадаад улс, олон улсын байгуллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, цуцлах;

21.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

21.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн хяналтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх журам тогтоох;

21.1.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдээллийг түгээх, статистик мэдээллийн нэгдсэн сан байгуулах журмыг тогтоох;

21.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи судалгаа, шинжилгээг холбогдох байгуллагаар хийлгэх;

21.1.8.үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг батлах;

21.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

22 дугаар зүйл. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

22.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

22.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн байгууллага, тэдгээрийн мэргэжлийн салбар, төрийн бус байгууллага хоорондын ажлын уяялдаа холбоог хангах;

22.1.3.төрийн захиргааны төв болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар салбар дундын эрх зүйн баримт бичиг боловсруулж, батлах;

22.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжлийн боловсон хүчний асуудлаар холбогдох байгууллагад санал оруулах;

22.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам тогтоох;

22.1.6.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаархи тайланг гаргах, хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох газар, олон нийтэд мэдээлэх;

22.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар олон улсын хамтын ажиллагаг хөгжүүлэх;

22.1.8.ажил олгогчоос төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг өөрчлөх саналыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд оруулах;

22.1.9.мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагыг байгуулах, бүтэц, орон тоо, дүрмийг батлах;

22.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

23 дугаар зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, түүний бүрэн эрх

23.1.Төрийн захиргааны байгууллага, ажил олгогчийн болон ажилтны эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл бүхий тэнцүү тооны гишүүдээс бүрдсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо /орон тооны бус/-г хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд байгуулж ажиллуулна.

23.2.Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг талуудын саналыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн Үндэсний хорооны дарга батална.

23.3.Үндэсний хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.3.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох;

23.3.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар санал, зөвлөмж гаргах;

23.3.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын шалтгаан, нөхцөлийг судлах, хэлэлцэх, зөвлөмж гаргах, саналаа холбогдох байгууллагад оруулах;

23.3.4.олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцид нэгдэн орох асуудлыг боловсруулахад төлөөлөө оролцуулах.

24 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

24.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.нутаг дэвсгэртээ үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнд шаардагдах төсвийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар тухайн шатны Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх;

24.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог хангаж, үйл ажиллагаг нь уялдуулан зохицуулах;

24.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

25 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

25.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлэх;

25.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

25.1.3.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

25.1.4.хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээ шуурхай авах;

25.1.5.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн нутаг дэвсгэртээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаг нь уялдуулах;

25.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

25.2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн хурал, дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

25.2.2.үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөлөөс иргэдийг хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

25.2.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

26 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт

26.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

26.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

26.1.2.гадаад, дотоодын байгуулллага, аж ахуйн нэгж, иргэний хандив;

26.1.3.гадаадын зээл, тусламж;

26.1.4.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

26.2.Төсвийн байгууллага улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйчилгээний зардлын 0,3 хувиас, аж ахуйн нэгж, байгуулллага үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.0 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

26.3.Энэ хуулийн 22.1.9-д заасан мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгуулллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

26.4.Иргэн, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи аливаа арга хэмжээний зардлыг хариуцахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт

27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал зөвлөл, ажилтан

27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /цlaaн/, ажил олгогч шууд хариуцна.

27.2.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл болон орон тооны ажилтан ажиллуулахад баримтлах норматив, зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм, ажилтны аюулын байдрын тодорхойлолтын загварыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

27.3.Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар энэ чиглэлийн мэргэжил эзэмшсэн, эсхүл мэргэшсэн хүнийг авч ажиллуулах ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь ажил олгогчийн шууд удирдлагын дор ажиллаж, түүний өмнө ажлаа бүрэн хариуцна.

27.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

27.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл болон ажилтны өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулан тавьсан шаардлагыг тухайн байгууллагын бүсад ажилтан, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг

28.1.Ажил олгогч нь дараахь үүрэгтэй байна:

28.1.1.үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

28.1.2.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагаа яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;

28.1.3.хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх;

28.1.4.ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

28.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;

28.1.6.ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам батлах, мөрдүүлэх;

28.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн байх;

28.1.8.аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах; аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;

28.1.9.хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах;

28.1.10.хэт халуун буюу хүйтэн, салхитай, хур тунадастай эзэг задгай газар, халаалтгүй байранд ажиллах байгаа ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын дагуу тур завсарлагын үед амрах, дулаацах, хоргодох зориулалтаар тоноглож тохижуулсан байраар хангах;

28.1.11.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоон мэдээллийн талаар тэмдэглэл хөтлөх, холбогдох байгууллагад мэдээлж байх;

28.1.12. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх;

28.1.13. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаар илэрсэн зөрчил, дутагдал, эрх бүхий этгээдийн гаргасан шаардлага, дүгнэлтийн дагуу тодорхой арга хэмжээ авч, эргэж мэдэгдэх;

28.1.14. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтаар нь зарцуулах;

28.1.15. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хүрц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;

28.1.16. Энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан этгээд нь өөрийн ажилласгадын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

28.2.Ажил олгогч нь дараахь эрхтэй байна:

28.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл байгуулах, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх;

28.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний төсөв, зардлыг баталж, хэрэгжүүлэх;

28.2.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хүрц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

29 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн осол, хүрц хордлогын үед авах арга хэмжээ

29.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хүрц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хүрц хордлогын хор уршигийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна.

29.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хүрц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд осол, хүрц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

29.3.Энэ хуулийн 29.2-т заасны дагуу гаргасан үйлдвэрлэлийн ослын актыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хүрц хордлогын дүгнэлтийг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тус тус хянана.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан ослын акт, хүрц хордлогын дүгнэлтийг хянасан улсын байцаагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

29.4.1.ослын акт, хүрц хордлогын дүгнэлтийг зөвшөөрч баталгаажуулах;

29.4.2.ослын акт, хүрц хордлогын дүгнэлтийг зөвшөөрөөгүй бол дүгнэлт гаргах.

29.5.Ажил олгогч энэ зүйлийн 29.1, 29.2-т заасан үүрэгээ биелүүлээгүй, эсхүл үйлдвэрлэлийн осол гарсан, хүрц хордлогод өртсөн дүгнэлтийг иргэн, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдэрлүүлнэ.

29.6.Үйлдвэрлэлийн осол, хүрц хордлогыг судалж бүртгэх зардлыг осол гарсан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

29.7.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хүрц хордлогын тухай мэдээг тогтоосон журмын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн статистикийн байгууллагад мэдээлнэ.

29.8.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хүрц хордлогыг нуун дарагдуулахыг хориглоно.

30 дугаар зүйл. Мэргэжлээс шалтгаалах өвчин, түүнтэй холбогдсон хөдөлмөр зохицуулалт

30.1.Мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

30.2.Үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас бий болсон хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацаог Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс шийдвэрлэнэ.

31 дүгээр зүйл. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

31.1.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллага хийнэ.

31.2.Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт нь, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа

бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ.

31.3.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

32 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

32.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараахь этгээд өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт тавина:

32.1.1.Улсын Их Хурал;

32.1.2.Засгийн газар;

32.1.3.улсын мэргэжлийн хяналтын байгууллага, алба, улсын байцаагч;

32.1.4. хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан;

32.1.5.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хяналтын алба;

32.1.6. ажилтны төлөөлөгчдийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага.

33 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналт

33.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосон хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч гүйцэтгэнэ.

33.2.Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.2.1.ажлын байранд ашиглагдаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, техникийн паспортын хөтөлтийн байдалд үзэлж шалгалт хийх;

33.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан иргэн, ажилтны ажил, үүргийн гүйцэтгэлтэй танилцаж заавар, зөвлөгөө өгөх;

33.2.3.өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд мэргэжлийн байгууллагаар туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн эсэхийг шалгах;

33.2.4.ажлын тусгай хувцас, нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээний байдалтай танилцах;

33.2.5.үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, ослын шалтгаан, хүчин зүйлийг тогтоосон байдалд хяналт тавих, энэ хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар дүгнэлт гаргах;

33.2.6.хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах ажлын байр нь стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах;

33.2.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

33.3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн эрүүл ахуйн ажлын зохион байгуулалттай танилцах, зөвлөгөө өгөх;

33.3.2.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл нь эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

33.3.3.хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгаанд хөдөлмөрийн эрүүл ахуйн дүгнэлт гаргах;

33.3.4.үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөл хийх, зураг төсөлд дүгнэлт гаргах;

33.3.5.ажлын тусгай хувцас, нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгсэл нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;

33.3.6.хуульд өөрөөр заагаагүй бол химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисыг ашиглалт, хадгалалтад хяналт тавих;

33.3.7.ажилтанд зориулсан ахуйн байрны хүрэлцээ, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэх, хөдөлмөрлөх орчны сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээний үр дүнг шалгаж, зөвлөгөө өгөх;

33.3.8.эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэг, мэргэжлээс шалтгаалсан

болон ажилтай холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хөдөлмөрийн нөхцөлд хийсэн хэмжилт, шинжилгээний үзүүлэлттэй холбон үнэлэлт өгөх;

33.3.9.мэргэжлээс шалтгаалсан болон ажлын байрны нөхцөлтэй холбоотой өвчнийг тогтооход ажлын байрны нөхцөлийн талаар санал, дүгнэлт гаргах;

33.3.10.хуульд заасан бусад бүрэн эрх

33.4.Хөдөлмөрийн хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.4.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартын шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах;

33.4.2.ажилтны эрүүл мэнд, амь насанд нь шууд аюул учруулах нөхцөл үүссэн тохиолдолд ажлаа зогсоох шаардлага тавих;

33.4.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн талаар илэрсэн зөрчлийг арилгуулах тодорхой хугацаатай шаардлагыг ажил олгогчид өгөх;

33.4.4.хөдөлмөрийн болон хамтын гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хүлээсэн үүргийн биелэлтийг аж ахуйн нэгж, байгууллагад шалгах, зөвлөгөө өгөх;

33.4.5.үйлдвэрлэлийн барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглаптад хүлээн авах, туршилт хийх комиссын бүрэлдэхүүнд оролцох;

33.4.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах;

33.4.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, хөдөлмөрийн болон хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;

33.4.8.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэжилтийг хангах талаар тавьсан шаардлага болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад санал оруулах;

33.4.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн ажил олгогчийн тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг зогсоох буюу хориглох саналаа холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

33.4.10. аж ахуйн нэгж, байгууллага, түүний нэгж, хэсгийн болон ажлын байр, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа нь ажилтны эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах нь тогтоогдсон тохиолдолд үйл ажиллагааг шууд зогсоох.

34 дүгээр зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тавих олон нийтийн хяналт

34.1.Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах болон төрийн бус байгууллага нь олон нийтийн хяналтыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

34.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар үнэн зөв мэдээлэл авах;

34.1.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн зөрчлийг арилгах шаардлагыг ажил олгогчид тавих;

34.1.3. хөдөлмөрийн болон хамтын гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээсэн үүргийн биелэлт, түүний явцыг дүгнэж, нийт ажилтанд мэдээлэх;

34.1.4. үйлдвэрлэлийн барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглаптад хүлээн авах, туршилт хийх комиссын бүрэлдэхүүнд оролцох;

34.1.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, санал өгөх;

34.1.6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн болон хамтын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;

34.1.7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэжүүлэх талаар болон хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа холбогдох байгууллагад тавих.

35 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт

35.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу аварга болон хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина.

35.2.Ажил олгогч дотоодын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй.

35.3.Ажилтны төлөөлөгч болон ажилтан нь аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт тавих үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага

36 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага

36.1.Ажил олгогчийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого гарсан бол 350 000-500 000 төгрөгөөр хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч торгоно.

36.2.Үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого хоёр ба түүнээс дээш удаа гарсан тохиолдолд албан тушаалтныг 1 000 000-2 000 000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 1 500 000-3 000 000 төгрөгөөр шүүгч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч торгоно.

36.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан евчин, хүрц хордлогыг нуун дарагдуулсан албан тушаалтныг 100 000-200 000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 200 000-250 000 төгрөгөөр хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, эсхүл шүүгч торгоно.

36.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг 200 000-250 000 төгрөгөөр, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүйгээр үйлдвэрлэлийн барилга байгууламжийг хамтран эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллагыг 500 000-1 000 000 төгрөгөөр хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч буюу шүүгч тус тус торгоно.

36.5.Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж байгуулах, машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, ашиглаптад өгөх, дараптат сав, шугам хоолойд тавигдах шаардлагын талаар мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж, хөдөлмөрийн эрүүл ахуйн дүгнэлт гаргуулаагүй, зөвшөөрөл аваагүй албан тушаалтныг 300 000-600 000, аж ахуйн нэгж, байгууллагыг 600 000-750 000 төгрөгөөр хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч буюу шүүгч тус тус торгоно.

36.6.Хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг буруу тогтоосон холбогдох албан тушаалтан болон эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын гишүүнийг 25 000-50 000 төгрөгөөр шүүгч торгоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад заалт

37 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэх

37.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогч, ажилтан болон хөдөлмөр эрхэлж буй этгээдийн хооронд үүссэн маргааныг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"4.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбогдсон хаврилцаат хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

"3.1.10."хөдөлмөрийн нөхцөл" гэж хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар,

эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нелеелех ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийг ";

3 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...хөдөлмөрийн аятай" гэснийг "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон" гэж, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...журмыг чанд" гэснийг "нийтлэг шаардлагыг" гэж, 79 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн "Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацаат харгалзан" гэснийг "Хөдөлмөрийн нөхцөл, ажилласан жилийг харгалзан ажилтанд" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн "3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.11, 3.1.12 дахь заалт, 6 дугаар бүлгийн 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 98, 99 дүгээр зүйл, 141 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 141.1.2, 141.1.7, 141.1.16, 141.1.17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 23-ны өдөр **Улаанбаатар хот**

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль тогтоомж

2.1.Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль тогтоомж нь Монгол улсын Үндсэн хууль[1], Боловсролын тухай[2] хууль, Бага, дунд боловсролын тухай[3] хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бүсад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын зорилго

3.1.Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд оршино.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."хүүхдийн цэцэрлэг" гэж (цаашид "цэцэрлэг" гэх) хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг;

4.1.2."тусгай цэцэрлэг" гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэзрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг;

4.1.3."сувиллын цэцэрлэг" гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны биеийн өсөлт, оюун ухааны хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг;

4.1.4."асрамжийн цэцэрлэг" гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны эцэг, эх, асран хамгаалагчгүй болох нь албан ёсоор тогтоогдсон өнчин, хагас өнчин хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг;

4.1.5."ортасгасан цагийн бүлэг" гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрээр нэг өдөрт үрэлэхлэх үйл ажиллагааны хугацаа 1-3 цагаар нэмэгдүүлэн ажиллаж байгаа бүлгийг;

[1]Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.
[2]Боловсролын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.
[3]Бага, дунд боловсролын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

4.1.6."богиносгосон цагийн бүлэг" гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрээр нэг өдерт үргэлжлэх үйл ажиллагааны хугацаат 1-3 цагаар хорогдуулан ажиллаж байгаа бүлгийг;

4.1.7."24 цагийн ажиллагаатай" гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хамтарсан шийдвэрээр ажлын таван өдер тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг болон бүлгийг;

4.1.8."үндсэн сургалт" гэж цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хичээл болон хүүхдийг хөгжүүлэх бусад үйл ажиллагааны цогцыг;

4.1.9."хувилбарт сургалт" гэж үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх "эзлжийн бүлгийн", "явуулын багшийн", "нүүдлийн бүлгийн" сургалтын үйл ажиллагааг;

4.1.10."эзлжийн бүлгийн сургалт" гэж боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг;

4.1.11."явуулын багшийн сургалт" гэж боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг;

4.1.12."нүүдлийн бүлгийн сургалт" гэж боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд зайлшгүй сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагаг;

4.1.13."туслах багш" гэж сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулахад багшид туслах үүрэгтэй, мэргэжлийн сургалтад хамрагдсан ажилтныг.

5.1.2.хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох;

5.1.3.хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах;

5.1.4.хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.

5.2.Цэцэрлэг нь Боловсролын тухай хуулийн 11.3-т заасан боловсролын стандартыг хэрэгжүүлнэ.

5.3.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6 дугаар зүйл. Сургалтын хэрэглэгдэхүүн

6.1.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн болон тоглоом, бусад хэрэглэгдэхүүн нь сургалтын орчны стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

6.2.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлсан журмын дагуу зохион байгуулна.

7 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

7.1.Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, мэдлэг, чадвар, дадал, хэвшлийг сургалтын явцад болон хичээлийн жилийн эцэст боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ.

7.2.Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Цэцэрлэг, түүний зохион байгуулалт

8 дугаар зүйл. Цэцэрлэг

8.1.Цэцэрлэг нь ердийн, тусгай, сувиллын, асрамжийн гэсэн хэв шинжтэй байна.

8.2.Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын стандартын дагуу асаргаа, сувилгаа,

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт

5 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт

5.1.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

5.1.1.бие бялдрын хувьд эрүүл чийрэг есгеж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох;

сургалтын үйлчилгээг дагнасан болон хосолсон хэлбэрээр явуулж болно.

8.3.Цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхэдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

8.4.Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

8.5.Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм болон аюулгүй байдлын дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8.6.Тусгай болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

8.7.Цэцэрлэг нь барилга байгууламж, сургалтын орчны стандарт, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдөнө.

8.8.Цэцэрлэгт эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш, эмч, тогоочоо болон үйлчилгээний бусад ажилтан ажиллана.

8.9.Цэцэрлэгийн нэг бүлэгт багш, туслах багш ажиллана.

8.10.Уртасгасан болон 24 цагийн ажиллагаатай нэг бүлэгт хоёр багш, гурван туслах багш ажиллаж болно.

8.11.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санхүүжилтээр төлбөртэй цэцэрлэг ажиллуулж болно.

8.12.Цэцэрлэг нь хүүхдийн эрүүл, аюулгүй сурч хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар хариуцан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, эцэг, эх, асран хамгаалагчтай гэрээ байгуулна.

8.13.Цэцэрлэг нь баг, хорооны нутаг дэвсгэрт салбар бүлэг ажиллуулж болно.

9 дүгээр зүйл. Цэцэрлэгийн үйл ажиллагааны зохион байгуулалт

9.1.Цэцэрлэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд үндэслэн ажиллах цагийг уян хатан тогтоож, уртасгасан, бүтиносгосон, 24 цагийн ажиллагаатай бүлэг ажиллуулж болно.

9.2.Цэцэрлэгийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.3.Байгаль, цаг уурын болон ниитийг хамарсан гамшигтай холбогдуулан тогтоосон онцгой дэглэм, хорио цээрийг харгалзан цэцэрлэгийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүрд нь өөрчлөх болно.

9.4.Цэцэрлэгийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаог энэ хуулийн 9.3-т зааснаас бусад нөхцөлд өөрчлөх, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг түр хугацаагаар хаахыг хориглоно.

9.5.Цэцэрлэгийн сургалтын цагийн жилийн доод хэмжээ, хичээсэн, хүүхдийг хөгжүүлэх бусад үйл ажиллагааны харьцаа, үндэсэн болон хувилбарт сургалтын цаг, бүлэг дүүргэлт, багш, хүүхдийн харьцаог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.6.Цэцэрлэгийн сургалтыг бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгээр зохион байгуулах бөгөөд нэг бүлэгт байх хүүхдийн тоо хангалттүй байгаа тохиолдолд холимог бүлгийн хэлбэрээр сургалт зохион байгуулж болно.

9.7.Цэцэрлэг нь сургалтын орчин, нөхцөл бүрдсэн тохиолдолд хоёр хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж болно.

9.8.Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн багш ажиллуулна.

9.9.Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Цэцэрлэгийн удирдлага

10 дугаар зүйл. Цэцэрлэгийн удирдлага

10.1.Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийг сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж төгссөн,

ажлын туршлагатай эрхлэгч удирдах бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч томилно.

10.2.Цэцэрлэгийн өөрийн удирдлага нь цэцэрлэгийн зөвлөл байх бөгөөд түүнийг Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу байгуулна.

10.3.Цэцэрлэгийн мэргэжил, арга зүйн удирдлагыг заах аргын нэгдэл хэрэгжүүлнэ.

10.4.Цэцэрлэгийн зөвлөлийн болон багш нарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10.5.Заах аргын нэгдлийн ажиллах жүрмыг багш нарын зөвлөлийн саналыг үндэслэн цэцэрлэгийн эрхлэгч батална.

11 дүгээр зүйл. Эрхлэгчийн нийтлэг эрх, үүрэг

11.1 Эрхлэгч нь дараахь эрхтэй:

11.1.1.холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэр гаргах хэрэгжүүлэх;

11.1.2.багш, ажилтныг сонгон авч ажиллуулах, өөрчлөх, чөлөөлөх;

11.1.3.сургалтын болон сургуулийн өмнөх боловсролын бусад үйлчилгээтэй холбогдсон асуудлаар эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгуллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх;

11.1.4.дотоод, гадаадын цэцэрлэг, сургууль, аж ахуйн нэгж, байгуллагатай хууль тогтоомжийн дагуу гэрээ, хэлцэл хийж, хамтран ажиллах;

11.1.5.хүүхдийг цэцэрлэгт элсүүлэх, чөлөөлөх, тэдний талаар шийдвэр гаргах;

11.1.6.сургалтын үйл ажиллагааны дэвшилтэт арга, хэлбэрийг турших, нэвтрүүлэх.

11.2.Эрхлэгч дараахь үүрэгтэй:

11.2.1.боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тайлагнах;

11.2.2.цэцэрлэгийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

11.2.3.цэцэрлэгийг багш, ажилтнаар хангах, хамт олныг төлөвшүүлэх, тэдний хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэргэшлийг дээшлүүлэх;

11.2.4.цэцэрлэгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаог төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

11.2.5.цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулах;

11.2.6.хүүхдийн аюулгүй хөгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

11.2.7.багш, ажилтны хөдөлмөрийн үр дүнг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох;

11.2.8.хамран сургах тойргийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсроп эзэмшүүлэх үндсэн болон хувилбарт сургалтад бүрэн хамруулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчид сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх;

11.2.9.хүүхэд, багш, ажилтны сургалтын орчин дахь эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

11.2.10.цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийг эрүүл мэндийн шинжилгээ, дархлаажуулалтад бүрэн хамруулахад анхаарах, хүүхдийн эрүүл, аюулгүй байх нөхцөлийг хангах;

11.2.11.сургалтын орчин, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын стандарт, норм, норматив, багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын харилцаанд оролцогчид

12 дугаар зүйл. Багш, түүний эрх, үүрэг

12.1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр дипломын болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана.

12.2.Багш нь багшлах эрхтэй байна.

12.3.Багшид заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн мэргэжлийн зэрэг олгоно.

12.4.Багшийн заах арга, мэргэжлийн ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтыг төвлөрсөн, бүсчилсэн болон зайны хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

12.5.Багш Боловсролын тухай хуулийн 43.1 дэх хэсэгт заасан нийгмийн баталгаагаар хангагдана.

12.6.Эцэг, эх, асран хамгаалагчаас шалтгаалан багш илүү цагаар ажилласан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчаас төлбөр авах асуудлыг цэцэрлэгийн эвлэлийн шийдвэр, эцэг, эх, асран хамгаалагчтай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

12.7.Багш нь Боловсролын тухай хуулийн 44.1-д заасан эрхээс гадна хүүхдийн сургалтын ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, хориглоход биечлэн оролцох эрх эдлэнэ.

12.8.Багш Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

12.8.1.багшийн ёс зүйн хэм хэмжээг сахиж биелүүлэх;

12.8.2.холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, цэцэрлэгийн эвлэлийн шийдвэрийг мөрдөх, тэдгээрийг хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах;

12.8.3.сургуулийн өмнөх боловсролын стандарт, сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, заах арга, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

12.8.4.хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчтай заавал зөвшилцөх;

12.8.5.хүүхдийн авьяас, чадвар, сонирхлыг нээн илрүүлж хөгжүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалахад эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

12.8.6.сургалтын үйл ажиллагааны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангах;

12.8.7.хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар цэцэрлэгийн эмч болон эцэг, эх, асран хамгаалагчид шаардлагатай мэдээлэл өгөх;

12.8.8.эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт тогтмол хамрагдах.

13 дугаар зүйл. Туслах багшийн эрх, үүрэг

13.1.Туслах багш нь дараахь эрх, үүрэгтэй:

13.1.1.бүлгийн эрүүл ахуй, ариун цэврийн норм, нормативыг хангах;

13.1.2.хүүхэд бүрийг асран халамжлах, эрүүл мэнд, ариун цэврийн зөв дадал, хэвшилтэй болоход туслах;

13.1.3.хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдээ асрах хөгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх;

13.1.4.хичээл, хүүхдийг хөгжүүлэх бусад үйл ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд нь багшид туслах;

13.1.5.эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт хамрагдах;

13.1.6.мэргэжлийн сургалтад хамрагдах нөхцөлөөр хангагдах.

14 дүгээр зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

14.1.Эцэг, эх, асран хамгаалагч дараахь эрхтэй:

14.1.1.хүүхдэдээ тохирох цэцэрлэгийн хэв шинж, үйлчилгээний хэлбэрийг сонгох;

14.1.2.цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах;

14.1.3.хүүхдийнхээ эрүүл мэнд, өсөлт хөгжил, боловсролын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа авах;

14.1.4.сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, санал гаргах ;

14.1.5.хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;

14.1.6.цэцэрлэгийг хөгжүүлэх үзэл баримтлал, хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох.

14.2.Эцэг, эх, асран хамгаалагч дараахь үүрэгтэй:

14.2.1.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг хариуцах;

14.2.2.хүүхдийг сургуульд элсэхийн өмнөх насанд нь сургуулийн өмнөх

боловсролын үйлчилгээнд заавал хамруулах, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах;

14.2.3.хүүхдээ сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахын өмнө эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, заавал хийх дархлаажуулалтад хамруулах;

14.2.4.сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хүүхдээ хамруулахтай холбогдон гарах тэсвэрийн зардлыг хариуцах;

14.2.5.өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, дэмжиж туслах;

14.2.6.хүүхэд сурч хүмүүжих, хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэхэд туслах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилт

15 дугаар зүйл. Санхүүжилт

15.1.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, ном, гарын авлага болон хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тогтоомоор хангах зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг хүүхдэд ногдох норматив зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

15.2.Явуулын багш, ээлжийн болон нүүдлийн бүлгийн сургалтын зардлыг нэг хүүхдэд ногдох зардлаар тооцон улсын төсвөөс санхүүжүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан, шаардлагатай үед зохих арга хэмжээ аваагүй төрийн захиргааны болон боловсролын байгуллагын гэм буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

16.2.Сургуулийн өмнөх боловсролын хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Боловсролын тухай хуулийн 48.2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь захиргааны шийтгэл хүлээлгэнэ:

16.2.1.энэ хуулийн 11.2.9, 11.2.10 дахь заалтыг биелүүлээгүйгээс хүүхэд, багш, ажилтны эрүүл мэндэд хохирол учирсан бол буруутай албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр торгох;

16.2.2.энэ хуулийн 14.2.3-т заасан үүргээ биелүүлээгүй, хүүхдийг халдварт өвчтэй үед нь сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамруулж бусад хүүхдэд халдварт өвчин тараах нөхцөлийг бүрдүүлсэн эцэг, эх, асран хамгаалагчийг 40000-50000 төгрөгөөр торгох.

16.3.Энэ хуулийн 16.2 дахь хэсэгт заасан шийтгэлийг шүүгч, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын хяналтын улсын байцаагч тус тус ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 23-ны өдөр **Улаанбаатар хот**

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бага, дунд боловсролын тухай хуулийн 19.1, 19.5 дахь хэсэг, 22.1.2 дахь заалтын "сургууль, цэцэрлэгийн" гэснийг "сургуулийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хуулийн 1.1 дэх хэсгийн "сургуулийн өмнөх болон" гэснийг, 10.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн гарчиг, 15.1, 15.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн гарчиг, 16.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн гарчиг, 19.1, 19.2, 19.3, 19.4, 19.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн гарчиг, 20.1.5, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн гарчиг, 21.1, 21.4, 21.6 дахь хэсгийн "цэцэрлэг," гэснийг, 19.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн гарчиг, 20.1, 20.2 дахь хэсгийн "/эрхлэгч/" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйл, 7.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйл, 16.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 2.1, 11.1, 33.2 дахь хэсгийн "Бага, дунд боловсролын тухай" гэсний өмнө "Сургуулийн өмнөх боловсролын тухай," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 40.2 дахь хэсгийн "хоолны зардлын зарим хэсэг," гэснийг "хоолны зардал," гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр — Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10 дахь хэсэгт дор дурдсан агуулагатай 15 дахь заалт нэмсүгэй:

"15.10.15.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр **Улаанбаатар хот**

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг:

"14.4.Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолны ялгах тэмдгийн тодорхойлолт, загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална."

2 дугаар зүйл.Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

"14.3.Дипломат цол олгосон хүнд үнэмлэх, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цол хүртсэн хүнд цолны ялгах тэмдэг тус тус олгоно."

3 дугаар зүйл.Дипломат албаны тухай хуулийн 14.4 дэх хэсгийн дугаарыг 14.5, 14.5 дахь хэсгийн дугаарыг 14.6 болгон тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр **Улаанбаатар хот**

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-ийн "хэлэлцэнэ." гэсний "мэдээлнэ." гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ын "аливаа" гэсний хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр **Улаанбаатар хот**

"УЛААНБААТАР ХОТЫН ШИНЭ НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ БАРИХ ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны банк хооронд 2008 оны 5 дугаар сарын 1-нд байгуулсан «Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл»-ийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 30 | Улаанбаатар хот

Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай

Улсын нөөцийн тухай хуулийн 12.1.2, 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлийг хавсралт ёсоор батлагдсугай.

2.Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрлөөр нь байршил, тоо хэмжээг тогтоохыг Засгийн газарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Улсын Их Хурлын 2008 оны 30 дугаар тогтоолын хавсралт

СТРАТЕГИЙН НӨӨЦИЙН БАРАА, МАТЕРИАЛЫН НЭР, ТӨРӨЛ

Д/Д	Нэр, төрөл
	1. Хүнсний бараа
1.	Гурил
2.	Төрөл бүрийн будаа
3.	Элсэн чихэр, ёотон
4.	Махан нөөш
	2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн
1.	Үр тарианы таримлын үр
2.	Хүнсний буудай
	3. Түүхий эд
1.	Цэвэр эс
2.	Угаасан ноолуур
	4. Шатахуун, тосолгооны материал
1.	Автобензин А-80
2.	Автобензин Аи-93
3.	Дизель түлш
4.	Онгоцны түлш ТС-1
5.	Моторын тос
6.	Мазут
7.	Түүхий нефть
	5. Хүний эм, багаж хэрэгсэл
1.	Ерөнхий мэдээгүйжүүлэх бэлдмэл
2.	Хэсгийг мэдээгүйжүүлэх бэлдмэл

3.	Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм
4.	Харшлын ба анафилаксын эсрэг эм
5.	Хордлого тайлах эм
6.	Нянгийн эсрэг бэлдмэл
7	Хэт ягаан туяанаас хамгаалах бэлдмэл
8.	Цус бүлэгнэлтэд нөлөөлөх эм
9.	Цусны бэлдмэл сийвэн орлох эм
10.	Зүрх судасны эм
11.	Үржлийн эсрэг халдваргүйжүүлэх бэлдмэл
12.	Байгалийн голомтод болон олон улсын хөл хориот халдварт өвчний үед хэрэглэх эм
13.	Шээлгэх эм, оношлогооны бодис
14.	Булчин сулруулах, унтуулах эм
15.	Бусад эм /ханиалга намдаах, давс, ус, хүчил, шүлтийн тэнцвэрт нөлөөлөх/
16.	Эмнэлгийн багаж хэрэгсэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 41** **Улаанбаатар хот**

Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай

Төсвийн байгуллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2009 оны төсвийн хүрээний мэдэгдлийн болон 2010-2011 оны төсвийн төсөөлийн үзүүлэлтүүдийг 1 дүгээр хавсралтаар, Засгийн газрын дунд хугацааны зорилтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтүүдийг баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Ганхуяг/, Төсвийн байнгын хороо /Л.Пүрэвдорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Улсын Их Хурлын 2008 оны
41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН БОЛОН 2010-2011 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2009 он	Төсөөлөл	
			2010 он	2011 он
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь	11.1	31.5	13.2
2.	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн дээд түвшин, хувь	6.0	5.0	5.0
	ДНБ-д эзлэх хувиар			
3	Төсвийн нийт орлогын дээд хэмжээ	37.3	33.2	32.0
4	Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	37.3	33.2	32.0
5	Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ	10.3	9.7	9.5
6	Төсвийн алдагдлын дээд хэмжээ	0.0	0.0	0.0
7	Хөрөнгийн зардлын доод хэмжээ	8.8	8.6	8.6

Улсын Их Хурлын 2008 оны
41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009-2011 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД

Засгийн газар "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д тусгагдсан стратегийн зорилт, арга хэмжээтэй уялдуулан дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийн хурдцыг нэмэгдүүлэх, эрдэс түүхий эдийн томоохон ордуудыг ашиглах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бататган хадгалах, инфляцийг нэг оронтой тоонд байлгах, гадаадын зээл, тусламж, улсын болон хувийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэглээг урамшуулах эдийн засгийн бодлого баримталж, эрчимтэй хөгжлийн үндэс суурийг баттай тавина.

Эдийн засгийн бодлого нь өсөлтийг урамшуулж, төсвийн орлого, гадаад зээлийн ашиглалтыг зохистой нэмэгдүүлэн, нийгмийн бодлого, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар ард иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлж сайн сайхан аж байдлыг хангах, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.

Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгална.

1.1.Эдийн засгийн бодит өсөлтийг дунд хугацаанд 10 хувиас бууруулахгүй байх.

1.2.Хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний хангамжийг сайжруулж, инфляцийн түвшинг дунд хугацаанд нэг оронтой тоонд байлгах.

1.3.Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг багасгаж гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

1.4.Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалах механизмыг бүрдүүлэн олон улсын санхүүгийн зах зээлд бонд арилжаалах ажлыг хэвшүүлэх.

Хоёр. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хадгална.

2.1.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгах зарчим бариманлаж, төсвийн алдагдлын хэмжээг "0" хувьтай байлгах.

2.2.Төсвийн хөрөнгө оруулалт, гадаад эх үүсвэрийг авто замын сүлжээг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэр, нефть бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр болон томоохон үйлдвэр, аж ахуйн нэгж барьж байгуулах, хот, суурин газрын агаарын бохирдлыг багасгахад чиглэгдсэн бүтээн байгуулалтын ажилд түлхүү ашиглах.

2.3.Төсвийн орлогын төлөвлөгөөг илүү бодитой, боломжит орлогын эх үүсвэрийг төсвийн төлөвлөгөөнд бүрэн дайчлан тусгаж, татварын тэгш, шударга байх зарчмыг баримтлан татвар хураалтыг эрчимжүүлэх.

2.4.Стратегийн зарим орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж уул, уурхайн салбарын орлогыг нэмэгдүүлэн, түүнээс Монгол Улсын иргэн бүрт шударга, үр ашигтай зарчмаар хуваарилах тогтолцоог бий болгож мөрдүүлэх.

Гурав. Бодит салбарын хөгжлийг дэмжиж, эдийн засгийн хөгжлийн хурдцыг нэмэгдүүлнэ.

3.1.Мянганы замын босоо, хэвтээ тэнхлэгийн гол замуудыг барьж байгуулах ажлыг үндсэнд нь дуусгаж, бүсийн тулгуур төвүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтцийг сайжруулж, орон нутагт хөгжлийн таталцлын төвүүд бий болгох замаар бизнес хөгжих таатай орчин бүрдүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах бодлого баримтлах.

3.2.Зүүн болон говийн бүсийн төмөр замын сүлжээг барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж, 2 дахь төмөр замын шугам барьж байгуулах ажлыг үе шаттай эхлүүлэх.

3.3.Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засгийн бүхий л хөшүүргээр дэмжих, шинжлэх ухаан технологийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологийн шинэчлэл хийх, шинэ технологт тулгуурласан үйлдвэрлэл, бүтээгдэхүүн бий болгохыг дэмжих.

3.4.Хөрш орнуудын болон олон улсын зах зээлийн боломжийг илүү ашиглах, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд барааа бүтээгдэхүүний хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх боломжийг эрэлхийлж бүрдүүлэх.

3.5.Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүдийг байгуулах ажлыг эрчимжүүлж, бүсүүдийн дэд бүтцийг бүрдүүлэн, түүний үйл ажиллагаанд эхлүүлэх.

3.6.Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах.

3.7.Эдийн засгийн өндөр өсөлтийг хангахад зөрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлж, түлш эрчим хүчний салбарт шинэчлэл хийх замаар зах зээлийн зарчимд шилжүүлэх бодлого баримтлах.

3.8.Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангаж, стратегийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нөөц, хангамжийг сайжруулах, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, "Атрын гурав дахь аян"-ыг зохион байгуулж улаан буудай, төмс, хүнсний ногоогоор өөрийн хэрэгцээгээ хангаж эхлэх.

3.9."Дөчин мянган айлын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын төвийн гэр хорооллуудыг дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол болгон төвлөрсөн инженерийн хангамжид холбох ажлыг хийж эхлүүлэх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах.

Дөрөв. Уул уурхайн салбарт баримтлах бодлого нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангах суурь болж, байгаль орчин, экологит ээлтэй байхад чиглэгдэнэ.

4.1.Уул, уурхайн салбараас улсын төсөвт орох орлогыг цаашид эдийн засгийн өндөр өсөлтийг хангах чиглэлийн хөрөнгө оруулалтад түлхүү ашиглах.

4.2.Оюу Толгойн алт, зэс, Таван толгойн нүүрс, Асгатын менгө, ураны зарим ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхайгаас улсын төсөвт орох орлогын хэмжээг нэмэгдүүлэх.

4.3.Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн нөөцийн хомсдол, агаар, ус, хөрсний бохирдол, доройтолтой тэмцэх эдийн засаг, эрх зүйн зохицуулалт, техник, технологийн чадавхийг дээшлүүлж, иргэд, байгууллагын оролцоонд түшиглэсэн нөхөн сэргээлт, хамгаалах хамтын үүрэг хариуцлага, хяналтын тогтолцоог бэхжүүлэх замаар экологийн болзошгүй аюул, эрсдэлийг бууруулах.

4.4.Газрын тосны хайгуул олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байгуулж бензин шатахуун үйлдвэрлэж эхлэх, импортын хараат байдлыг арилгах.

4.5.Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлж, эрчим хүчний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэн өөрийн хэрэгцээг бүрэн хангах.

4.6.Эрдэнэтийн зэсийн баяжмалыг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын орлогыг нэмэгдүүлэх.

Тав. Ядуурлыг бууруулах, хүний хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.Эдийн засгийн өсөлтийн үр шимээр бүтээгдсэн нийгмийн баялгийг иргэдэд шударга хуртээх оновчтой арга хэрэгслийг бүрдүүлэх чиглэлээр "Эх орны хишиг сан"-г бүрдүүлэх, зарцуулах эрх зүйн орчинг бий болгох.

5.2.Гадаадын буцалтгүй тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад түншүүдтэй идэвхтэй хамтран ажиллах.

5.3.Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляц, эдийн засгийн өсөлт, төсвийн боломжтой уялдуулан нэмэгдүүлэх.

5.4.Хүн амын өсөлтийг урамшуулах хүрээнд хүүхэд, гэр бүл чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг үргэлжлүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөрийн төв бирж байгуулж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах.

5.5.Нийгмийн даатгалын сангуудын тодорхой хэсгийг хөрөнгийн зах зээлд оруулж менежмент хийх нөхцөл, бололцоог бүрдүүлэх, түүний санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, бие даасан байдлыг хангах.

5.6.Бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлж, өрөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн ур чадвартай мэргэжлийн ажилтан бэлтгэх.

5.7.Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, улсын болон хувийн эмнэлэгүүдийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэлхийн жишигт ойртсон орчин үеийн иж бүрэн оношилгооны төвүүдийг байгуулах.

5.8.Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж, үйлчилгээг бий болгож, хүн ам

ялангуяа эх, хүүхэд, ядуу болон бусад эмзэг бүлгийн хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралт, ашиглалтыг нэмэгдүүлэх.

5.9.Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж эрүүл мэнд, боловсрол, жендер, байгаль орчны талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэг-жүүлэх.

5.10.Монгол Улсын олон улсын болон бус нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааг бататгах.

Зургаа. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна.

6.1.Төрийн захиргааны байгууллагуудын иргэдэд үзүүлдэг үйлчилгээг шуурхай болгох үүднээс цахим хэлбэрийн үйлчилгээг нэвтрүүлж, хэвшүүлэх.

6.2.Орон нутгийн бие даасан байдлыг хангах ажлын хүрээнд санхүүгийн чадавхийг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

6.3.Иргэний нийгмийн төлөөлөл, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлдэг ажлыг өргөжүүлэх.

6.4.Эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд хариуцлагын тогтолцоог эрс дээшлүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай хүргэж, ил тод байдлыг хангах.

6.5.Шийдвэр гаргах түвшинд олон нийтийн оролцоог хангаж, иргэний нийгмийн хяналтын үр ашигтай тогтолцоог бүрдүүлж ажиллах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 43** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 27 дугаар бүлгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

27		2716.00.00	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн	0-5
			Эрдэс түлш, битумын эрдэс, эрдэс лав	5
			Цахилгаан эрчим хүч	5

2.Энэ тогтоолд заасан хязгаарт багтаан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох эрхийг Засгийн газар /С.Баяр/-т олгосугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор "Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалт"-ыг хавсралтаар батлагсугай.

2.Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг уг объектыг ашиглаглаад хүлээж авсаны дараахь эхний жил 30 хувь, 2 дахь жил 30 хувь, 3 дахь жил 40 хувиар тус тус тооцон жил бүрийн тесвийн төлөвлөгөөнд тусгаж байхыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Улсын Их Хурлын 2008 оны 47 дугаар тогтоолын хавсралт

ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭН ДАРАА ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР БАРИХ АВТО ЗАМ, ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж /км/	Баригдах хугацаа	Төсөвт өртөг /сая төг/
	I. АВТО ЗАМ			
1	Өлгий - Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	45	2009-2010	9,000.0
2	Тосонцэнгэл - Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	542	2010-2016	135,500.0
3	Мөрөн /Хөвсгөл/ - Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	152	2011-2012	37,750.0
4	Мөрөн /Хөвсгөл/ - Тариат чиглэлийн хатуу хучилттай авто зам	100	2008-2010	22,000.0
5	Манхан - Зэрэг - Дарви чиглэлийн хатуу хучилттай авто зам	100	2009-2011	27,000.0
6	Арвайхээр - Баянхонгор чиглэлийн хатуу хучилттай авто зам	107	2008-2009	23,540.0
7	Баянхонгор - Алтай чиглэлийн хатуу хучилттай авто зам	128	2010-2012	32,750.0

8	Улаанбаатар - Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто зам	100	2008-2009	22,000.0
9	Мандалговь - Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто зам	163	2008-2011	38,050.0
10	Даланзадгад - Тавантолгой - Оюутолгой чиглэлийн хатуу хучилттай авто зам	251	2008-2010	73,900.0
11	Өндерхаан - Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	143	2008-2011	33,800.0
12	Өндөрхаан - Дадал чиглэлийн хатуу хучилттай авто зам	210	2009-2012	52,500.0
13	Түмэнцогт - Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто зам	100	2009-2010	23,500.0
14	Баруун-Урт - Эрдэнэцагаан - Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам	290	2008-2010	68,150.0
15	Сайншанд - Хамарын хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам	30	2008-2010	7,500.0
16	Хүжирт - Төвхөн хийд - Орхоны хүрхрээ - Найманнуур - Уянга чиглэлийн хатуу хучилттай авто зам	138	2009-2011	30,400.0
17	Архангай аймгийн Донгой - Чулуутын чиглэлийн хатуу хучилттай авто зам	55	2009-2011	12,000.0
18	Архангай аймгийн Тэрхийн гүүр - Хангай чиглэлийн хатуу хучилттай авто зам	22	2009-2011	4,400.0
19	Архангай аймгийн Бэлх - Өндөр-Улаан чиглэлийн хатуу хучилттай авто зам	6	2009-2011	1,200.0
20	Архангай аймгийн Цэнхэр сумыг дайрсан төв замаас Халуун ус чиглэлийн хатуу хучилттай авто зам	30	2009-2010	6,000.0
21	Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам	63	2008-2010	15,750.0
22	Дархан-Алтанбулагийн авто замаас Шаамар - Цагаанхуур - Түшиг чиглэлийн хатуу хучилттай авто зам	135	2008-2010	33,750.0
23	Дулаанхаан - Ёроо - Хүдэр чиглэлийн хатуу хучилттай авто зам	113	2008-2010	28,250.0
24	Сэлэнгэ аймгийн Баянгол - Мандал чиглэлийн хатуу хучилттай авто зам	48	2008-2010	12,000.0
25	7 буудлаас Шарга морьтын ам хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэлт /Улаанбаатар хот/	10	2009	5,500.0
26	Бэлх - Сэлх чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот/	5	2009	1,200.0
27	Санзайн авто замаас Хандгайт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот/	3	2008-2009	600.0
28	Жигжид - Гүнтийн чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот/	3	2009	600.0
29	Санзайн авто замаас Хуурай мухар чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот/	2	2009-2010	400.0
30	Саппорогийн аюулгүйн тойргийн хоёр түвшний огтлолцол /Улаанбаатар хот/	1	2008-2009	15,000.0
31	Баянбүрдийн уулзварын хоёр түвшний огтлолцол /Улаанбаатар хот/	1	2009-2010	15,000.0

32	Энхтайваны өргөн чөлөөнөөс Жанжин клуб чиглэлийн хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот/	0.8	2009	250.0
33	Ажилчны гудамжийг Нарны замтай холбох төмөр зам дэргүүрх гүүрэн гарц /Улаанбаатар хот/	0.5	2008-2009	8,000.0
	ДҮН	3097.3		797,240.0
	II. ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ			
1	Дундговь аймгийн Мандалговь - Өмнөговь аймгийн Тавантолгой - Оюутолгойн 2 хэлхээтэй 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	429	2008-2010	165,000.0
2	Өмнөговь аймгийн Нарийнсухайт - Ноён - Сэврэйн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	145	2008	1,320.0
3	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан - Богдын 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	80	2008-2009	1,500.0
4	Завхан аймгийн Түдэвтэй - Асгат - Баянтэсийн 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	90	2008	463.0
5	Баян-Өлгий аймгийн Цагааннуур - Ногооннуурын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	48	2008	320.0
6	Ховд аймгийн Дарви - Говь-Алтай аймгийн Хөхморьтын 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	90	2008-2009	1,284.0
7	Говь-Алтай аймгийн Цогт - Бигэрийн 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	77	2008-2009	1,115.0
8	Баянхонгор аймгийн Бууцагаан - Хүрээмаралын 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	43	2008-2009	653.0
9	Баянхонгор аймгийн Хүрээмарал - Баянбулагийн 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	52	2008-2009	770.0
10	Дорнод аймгийн Мардай - Чулуунхороотын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	160	2008-2009	3,740.0
11	"40000 айлын орон сууцны хөтөлбөр"-ийн хүрээнд Буянт-Ухаа хорооллын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ /дэд станц, РП-8, ТП-53/	47	2008	20,100.0
12	Улаанбаатар хотод 8.7 км кабелийн суваг шинээр барьж, 6-35 кВ-ын 45 км кабель шугамыг суваг оруулах	53.7	2008-2009	7,800.0
13	Улаанбаатар хотын 6-10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт	29	2008	1,300.0
	ДҮН	1343.7		205,365.0
	НИЙТ ДҮН			1,002,605.0

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр **Дугаар 48** **Улаанбаатар хот**

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сааруулах, хангалтыг найдвартай, тасралтгүй болгох зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн доод хэмжээг 2008 онд багтаан 120 мянган тонн буюу 2 сарын хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж түүнд шаардагдах 189.8 тэрбум төгрөгийн, 2009 онд багтаан 180 мянган тонн буюу 3 сарын хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж түүнд шаардагдах 284.8 тэрбум төгрөгийн газрын тосны

бүтээгдэхүүнийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5-д заасны дагуу бензин, шатахууны нөөц хэлбэрээр байршуулах, нөөцийг хадгалахад нэмж шаардагдах сав барих ажлыг эохион байгуулах;

2/импортлогч компаниудад газрын тосны бүтээгдэхүүний 2008 оны 4, 5 дугаар сарын жижиглэн худалдаалах үнийн зөрүүгийн алдагдалд 7.9 тэрбум төгрөгийг Эрсдлийн сангаас олгох;

3/газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, 2008 оны 3 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/газрын тосны хайгуул болон олборлолтыг эрчимжүүлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Монгол Улсад ногдох газрын тосыг боловсруулах болон нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг 2009 онд багтаан хангах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих, татварын болон эдийн засгийн бусад аргаар урамшуулах талаар санал боловсруулах;

5/эдийн засгийн салбарт цаашид хамтран ажилах, газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой, баталгаатай байлгах, түүхий газрын тос импортоор авч дотоддоо боловсруулах чиглэлээр ОХУ-тай хэлэлцээ хийх, БНХАУ, БНКаУ, Ойрхи дорнодын болон бусад орнуудаас газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийг 2008 онд багтаан судлаж холбогдох хэлэлцээ хийх;

6/үнийн хөнгөлөлтийн карт өгөх, татаас, нөхөн олговор олгох зэргэцэр үнийн өсөлтөд илүүтэй өртөж байгаа нийгмийн эмзэг бүлэгт оновчтой чиглэсэн дэмжлэг үзүүлэх бодлого баримтлах, цаашид газрын тосны бүтээгдэхүүний үнэ тогтвортой өсөх, хомсдол үүсэх хандлагатай байгааг нийт байгууллага, иргэдэд анхааруулж, хэрэгцээгээ зөв тодорхойлж, хэмнэлттэй хэрэглэж төлөвшүүлэх талаар сурталчлах, шаардлагатай бусад арга хэмжээг авах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо/Д.Ганхуяг/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр | **Дугаар 49** | **Улаанбаатар хот**

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.2, 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Жамбалсүрэнгийн Нарантуяаг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Шилагарьдийн Солонго, Батнямын Алтанжаргал нарыг томилсугай.

3.Энэ тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр | **Дугаар 50** | **Улаанбаатар хот**

Орон даяар гашуудал зарлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. 2008 оны 5 дугаар сарын 26, 27-нь өдрүүдэд болсон цаг агаарын аюултай үзэгдэлд Сүхбаатар, Хэнтий, Дорнод зэрэг аймгуудад олон хүн нэрвэгдэж харамсалтайгаар амь үрэгдсэнд эмгэнэн 2008 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 09.00 цагаас мөн өдрийн 21.00 цаг хүртэлх хугацаанд орон даяар гашуудал зарласугай.

2.Гашуудлын үеийн дэгийг тогтоож хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Малчдын орлогыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хэрэглэгчдийн махны хангамжийг сайжруулах, ноолуурын үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгах нь:

1.1.мал, махыг малчдаас худалдан авч, хот суурин газрын хэрэгцээнд нийлүүлэх иж бүрэн арга хэмжээний саналыг боловсруулан Улсын Их Хурлд өгөн мэдүүлж шийдвэрлүүлэх;

1.2.чанар, зэрэглэлийг нь харгалзан 1 кг монгол ямааны ноолуурыг 30.000-32.000 төгрөгөөс доошгүй үнээр малчдаас худалдан авсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний аж ахуйн нэгжүүдэд Хөренгө оруулалт, хөгжлийн сангаас эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасыг бүрэн олгох замаар зохион байгуулах;

1.3.малчдаас ноолуур худалдан авах үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газраас тодорхой журам гарган хэрэгжүүлэх.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 5 дугаар сарын 30-ны өдөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 79 | Улаанбаатар хот

Аж ахуйн чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан Аюурзанийн Энхжавыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 05-ны өдөр | Дугаар 80 | Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн алба тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Пхагвааагийн Менхбаатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 05-ны өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын орон тоо батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.4-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай болсонтой холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсөнд шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тесвийн багцад тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан 19 дүгээр хавсралтын "Гишүүд" гэсэн хэсэгт "-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга" гэсэн заалт нэмж, мөн хавсралтын "Нарийн бичгийн дарга–Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга" гэснийг "Нарийн бичгийн дарга-орон тооны" гэж өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 12-ны өдөр **Дугаар 87** **Улаанбаатар хот**

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Эль-Кувейт хотноо үзэглэсэн "Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын санамж бичиг"-ийг батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

САНГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 99** **Улаанбаатар хот**

Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Маньбадрахын Ганболдыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.
Улаанбаатар-12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэгдсэн хуудас 5